

## ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2024 оны 11 дүгээр сарын 27

Улаанбаатар хот

Байгууллагын дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны А/120 дугаар тушаалаар баталсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлаг, байгууллагын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал”-д үндэслэн эрсдэлийн үнэлгээг хийлээ.

Эрсдэлийг бууруулах, удирдах зорилгоор төв болон боомт, орон нутаг дахь нэгжүүдийн 2024 онд зохион байгуулсан үйл ажиллагаа, хэрэгжүүлсэн арга хэмжээнд тулгуурлан 7 эрсдэлийг тодорхойлж, дүн шинжилгээ хийн учирч болох эрсдэлийн ангилал тус бүрийг үнэлэхэд 85 хувиар дүгнэгдлээ.

Тайлант хугацаанд эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний хүрээнд байгууллага дотооддоо арилган бууруулж, урьдчилан сэргийлэх зорилгоор дараах ажлыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолыг үндэслэн байгууллагын даргын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Б/105 дугаар тушаалаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг шинээр томилохдоо албан ажлын онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 04 дүгээр сарын 17-ны өдрөөс олгож байна.

- Байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөх төлбөрийг 34,000 төгрөг, унааны нөхөх төлбөрийг 1000 төгрөг болгон нэмэгдүүлэн шинэчлэн тогтоож 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон олгож байна. Албан хаагчид төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжиж, хууль тогтоомжийн дагуу авах нэмэгдэл хөлсний төрөл нэмэгдсэн, хоол, унааны нөхөх төлбөрийг нэмснээр байгууллагын нийт албан хаагчдын 79.7 хувийн сарын цалин, хөлс 49-79 хүртэл хувиар өсөж, албан хаагчдыг хилийн боомт, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаа сайжирснаар мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх боломж бүрдсэн.

- Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын даргын 2024 оны 01-02/21, 01-02/27, 02/35, 01-02/48, 01-02/51, 01-02/58 дугаар буюу 6 удаагийн удирдамжаар Агаарын замын боомт хариуцсан газарт 2 удаа, Зүүн бүс дэх газар, Санхүү, хангалт үйлчилгээний газар, Баруун бүс дэх газар, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс, Хойд бүс дэх газарт төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, мэргэжил, арга зүйгээр ханган, үр дүнг удирдлагад танилцуулж ажилласан.

- Тайлант хугацаанд 2022 оны хөрөнгө оруулагчийн 262 хадгаламжийн нэгжийн 5898 хуудас баримтыг PDF өргөтгөлтэй цахимжуулж, 112 хадгаламжийн нэгжийн 707 хуудас нийт 374 хадгаламжийн нэгжийг цахимжуулж, и-архив программд холбож баримтын эх хувийг ашиглалтаас чөлөөлж эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авсан.

- Төвийн байранд байрлах А, Б хадгаламжийн санд “Болор ариусгал” ХХК-иар 05 дугаар сарын 28, 11 дүгээр сарын 11-ний өдөр хортон шавж устгалын ажил хийлгэж, архивын баримтыг гадны эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.

Байгууллагын хэмжээнд тохиолдож буй эрсдэлүүдийг дахин үнэлэхэд бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, төсөв хөрөнгөөс шалтгаалсан болон дээд шатны байгууллагаас хамааралтай эрсдэлүүд байна. Үүнд:

Нэг. Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл:

Дараа жилийн төсвийг батлахдаа байгууллагын өмнөх жилийн гүйцэтгэлээр баталдаг. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан төсвийн хүрэлцээгүй байдал үүссэнээр батлагдсан төсвийн ангиллыг хэтрүүлэх, зориулалтын бусаар зарцуулах эрсдэл

Хоёр. Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын чиглэлээр:

Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах эрсдэл

Гурав. Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл:

“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх эрсдэл

Дээрх эрсдэлийн үнэлгээг хүснэгтээр харуулбал:

*Хүснэгт 1. Эрсдэлийн үнэлгээний матриц*

ТОХИОЛДОХ МАГАДЛАЛ (тоон хэмжээс)	5	5	10	15	20	25
	4	4	8	A1, A2, B1	Г2	20
	3	3	Г1	9	12	15
	2	Б2	4	Б1	8	10
	1	1	2	3	4	5
	0	1	2	3	4	5
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ (Тоон хэмжээс)						

*Хүснэгт 2. Ач холбогдолын зэрэг тодорхойлох хүснэгт*

Аудит хийгдэх эрсдлүүд	Эрсдэлийн нийт тоон түвшин	Ач холбогдолын зэрэг	Аудит хийгдэх эсэх
Г2	15-25	Их	Хамгийн их баталгаа өгөх аудит хийх
A1, A2, B1	12-20	Дунд	Байгууллагын түвшинд зохион байгуулах
Б1, Г1, Б2	1-10	Бага	Аудит хийх шаардлагагүй

*Хүснэгт 3. Эрсдэл ангилсан хүснэгт*

Д/д	Аудит хийгдэх эрсдлүүд	Үйл ажиллагааны чиглэл	Тодорхойлсон эрсдэл
1	B1	Хэрэгцээ шаардлага буюу төсөв, санхүүгийн эрсдэл	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх,

			санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх
2	A1	Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гаргахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх
3	A2	Нийцлийн буюу эрх зүйн зохицуулалтын эрсдэл	Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах
4	B1	Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Албан хаагчдын цалин хөлс бага, алслагдсан хилийн боомт, ажиллаж амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс ажиллах тогтворгүй байдал үүсэх
5	G1	Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл	Хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдаа гэнэтийн халдлага, хорио цээр, халдварт өвчнөөс сэргийлэх
6	G2	Бусдаас хамааралтай буюу гадаад хүчин зүйлсийн эрсдэл	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх
7	B2	Үйл ажиллагааны буюу гүйцэтгэл, зохион байгуулалтын эрсдэл	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх

**ДӨРӨВ. ЭРСДЭЛИЙГ СААРУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БУЮУ  
ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ**

Д/д	Байгууллага дотооддоо удирдаад арилгаж, бууруулж, урьдчилан сэргийлж болох эрсдэл	Эрсдэлийг сааруулах хариу арга хэмжээ
1	2	3
1	Хангамж, бараа материалын зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал хүрэлцэхгүй байх, санхүүгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэх	<p>Төсвийн хүрээний мэдэгдэлд суурилсан 2025 оны төсвийн хязгаарын саналыг бодит хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 01/1124, 07 дугаар сарын 08-ны өдрийн 01/1400 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн энэ оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг 01/177, 01/865, 01/1082, 01/1888, 01/2140 дугаар албан бичгээр 5 удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, холбогдох зардлыг шийдвэрлүүлсэн. Батлагдсан төсвийн хүрээнд төсвийг хэмнэлттэй зарцуулан өр төлбөр үүсгэхгүй ажиллаж байна.</p> <p>2025 оны төсвийн төслийн танилцуулга, тайлбарыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яаманд Санхүү, хангалт үйлчилгээний газрын дарга очиж танилцуулан, УИХ-д 21.4 тэрбум төгрөгөөр танилцуулагдсан.</p> <p>Санхүүгийн үйл ажиллагаанд зөрчил, дутагдал үүсэхээс урьдчилан сэргийлж сахилга батыг сайжруулах талаар 03 дугаар сарын 25-наас 28-ны өдрүүдэд хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүдийн нэгдсэн сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулав.</p>

		<p>Дотоод аудитын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, байгууллагын даргын 2024 оны 01-02/21, 01-02/27, 02/35, 01-02/48, 01-02/51, 01-02/58 дугаар буюу 6 удаагийн удирдамжтай төлөвлөгөөт болон гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж, мэргэжил, арга зүйгээр ханган, үр дүнг удирдлагад танилцуулж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Зүүн бүс дэх газрын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 05 дугаар сарын 06-наас 10-ны өдрүүдэд;</li> <li>-Агаарын замын боомт хариуцсан газрын зөрчил шалган шийдвэрлэлт, захиргаа, санхүүгийн 2023 он, 2024 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагаанд 05 дугаар сарын 20-ноос 24-ний өдрүүдэд;</li> <li>-Санхүү, хангалт үйлчилгээний газрын 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагаанд 06 дугаар сарын 24-нөөс 07 дугаар сарын 01-ний өдрүүдэд;</li> <li>-Баруун бүс дэх газрын 2024 оны эхний хагас жилийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд; Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн 2023 он, 2024 оны эхний хагас жилийн захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 09 дүгээр сарын 15-наас 21-ний өдрүүдэд;</li> <li>-Агаарын замын боомт хариуцсан газрын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 10 дугаар сарын 08-ны өдөр;</li> <li>-Хойд бүс дэх газрын 2024 оны 01-03 дугаар улирлын захиргаа, санхүүгийн үйл ажиллагаанд 11 дүгээр сарын 06-наас 09-ний өдрүүдэд.</li> </ul>
2	<p>Хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг харьяатаас гаргахыг шаардах, аль нэг улсынхаа иргэний харьяаллаа сонгохыг тулгах эрх зүйн зохицуулалт байхгүйгээс хоёрдмол харьяалалтай иргэд нэмэгдэх</p>	<p>Байгууллагын даргын 2009 оны 09 дүгээр сарын 14-ний өдрийн “Хоёрдмол харьяалалтай иргэдийн бүртгэл, судалгаа хөтлөх тухай” 275 дугаар тушаалын дагуу хоёрдмол харьяалал үүсгэсэн иргэдийг илрүүлсэн даруй тогтмол бүртгэлжүүлж байна.</p> <p>Гадаадын иргэний бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд 53 улсын 5007 иргэн бүртгэлтэй байгаагаас тайлант хугацаанд 247 иргэн шинээр бүртгэсэн байна.</p> <p>Баян-Өлгий аймаг дахь хэлтсийн даргын 05 дугаар сарын 28-ны өдөр баталсан Хоёрдмол харьяаллын чиглэлээр 2024 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.</p> <p>Монгол Улсын болон БНКаЗУ-ын хоёрдмол харьяалал үүсгэсэн 18 иргэнтэй ярилцлага хийж, аль нэг улсын иргэний харьяаллаа сонгох талаар зөвлөгөө өгсөн.</p> <p>Энэхүү ажлын хүрээнд 3 иргэн БНКаЗУ-ын иргэний харьяатаас гарч, эрх бүхий байгууллагын тодорхойлолт авсан тул Монгол Улсын харьяатаас гарахгүйгээр гадаад улсын харьяат болсон иргэний оршин суух зөвшөөрлөөс хасалт хийсэн.</p> <p>“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/03 дугаар тушаалыг үндэслэн журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, хуулиар эрх олгосон заалтыг хүчингүй болгох хүрээнд Засгийн газрын 2003 оны 62 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнд тавих шалгуурыг тогтоох журам”-ыг Харьяатын тухай хуульд тусган хуулийн төслийг боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/339 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p> <p>Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж 09 дүгээр сарын 10, 10 дугаар сарын 09-ний өдрүүдэд танилцуулгыг Захиргаа,</p>

3	<p>Нийтээр амрах баярын өдөр болон 7 хоног бүрийн амралтын өдөр, эсхүл ажлын бус цагаар гадаадын иргэний зөрчлийг илрүүлэн түр саатуулах тохиолдолд жижүүрийн шүүгч байдаггүйгээс Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа удаашрах</p>	<p>удирдлагын газарт хүргүүлэн ажилласан.</p> <p>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд гадаадын иргэнийг саатуулах эрх зүйн зохицуулалтад оруулах өөрчлөлтийн санал болон одоо хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэлийн талаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газарт 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдөр танилцуулга хүргүүлсэн.</p> <p>“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй шийдвэрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай” Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэл, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/03 дугаар тушаалыг үндэслэн журмаар зохицуулсан харилцааг хуульд тусгах, хуулиар эрх олгосон заалтыг хүчингүй болгох хүрээнд Засгийн газрын 2021 оны 193 дугаар тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах, албадан гаргахаас чөлөөлөх болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 52 дугаар тушаалаар баталсан “Барьцаа гаргах, буцаан олгох, барьцааны хэмжээ тогтоох журам”, байгууллагын даргын 2017 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлэх, гарахыг түдгэлзүүлэхийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх тухай журам”-ыг тус тус хуульд тусган Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан 2024 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 01/339 дугаар албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.</p>
4	<p>Албан хаагчдын цалин хөлс бага, алслагдсан хилийн боомт, ажиллаж амьдрах орчин нөхцөл бүрэн хангагдаагүйгээс ажиллах тогтворгүй байдал үүсэх</p>	<p>Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ”-г үндэслэн байгууллагын даргын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Б/105 дугаар тушаалаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдыг шинээр томилохдоо албан ажлын онцгой нөхцөл, цол, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 04 дүгээр сарын 17-ны өдрөөс олгож эхэлсэн.</p> <p>Байгууллагын даргын 04 дүгээр сарын 26-ны өдрийн А/154 дүгээр тушаалаар төв, хилийн боомт, орон нутаг дахь нэгжийн албан хаагчдын ажлын нэг өдрийн хоолны зардлын нөхөн төлбөр болох 15,000 төгрөгийг 34,000 төгрөг, унааны нөхөн төлбөр болох 500 төгрөгийг 1000 төгрөг болгон нэмэгдүүлэн шинэчлэн тогтоож, 04 дүгээр сарын 01-ний өдрөөс тооцон олгож байна.</p> <p>Албан хаагчид төрийн тусгай албан тушаалын ангилал, зэрэглэлд шилжиж, хууль тогтоомжийн дагуу авах нэмэгдэл хөлсний төрөл нэмэгдсэн, хоол, унааны нөхөн төлбөрийг нэмснээр байгууллагын нийт албан хаагчдын 79.7 хувийн сарын цалин, хөлс 49-79 хүртэл хувиар өсөж, албан хаагчдыг хилийн боомт, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаа сайжирснаар мэргэшсэн, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх боломж бүрдлээ.</p> <p>Байгууллагын даргын 01 дүгээр сарын 17-ны өдрийн Б/20, Б/21, 02 дугаар сарын 21-ний өдрийн Б/58, 04 дүгээр сарын</p>

		<p>26-ны өдрийн Б/102, 05 дугаар сарын 20-ны өдрийн Б/128, Б/129, Б/130, 05 дугаар сарын 24-ны өдрийн Б/133 дугаар тушаалын дагуу хилийн боомт, орон нутгийн нэгжид ажиллаж буй 8 хяналтын улсын байцаагчид ажилласан хугацааны урамшуулалд нийт 271,045.632 төгрөгийг олгосон.</p> <p>Гадаад сургалтад төв байгууллагаас 47, хилийн боомт, орон нутаг дахь нэгжээс 15, удирдлагын академийн богино дунд хугацааны мэргэшүүлэх сургалтад төв байгууллагаас 13, хилийн боомт, орон нутаг дахь нэгжээс 6 нийт 81 албан хаагчийг хамруулж мэдлэг, ур чадварыг нь дээшлүүллээ.</p> <p>Хойд, Зүүн бүс дэх газрын хариуцан ажилладаг Ханх, Сүмбэр автозамын боомт дахь албан хаагчдын амьдрах байранд иж бүрэн засварын ажил хийж гүйцэтгэн, Өмнөд бүс дэх газрын албаны байрыг 10 дугаар сарын 08-ны өдөр хүлээн авч ашиглалтад оруулсан.</p>
5	Хилийн боомтод ажиллаж буй албан хаагчдаа гэнэтийн халдлага, хорио цээр, халдварт өвчнөөс сэргийлэх	<p>Хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд аймгийн Онцгой байдлын газартай хамтран баталсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Агаарын замын боомт хариуцсан газар нь “Чингис хаан” олон улсын нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу жил бүр тодотгол хийж, гамшиг осол тохиолдсон үед ажиллах шуурхай штаб, бүлэг байгуулан, бүлгүүдийн ажил үүргийн хуваарийг албан хаагчдад танилцуулан бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p> <p>Хойд бүс дэх газар 02 дугаар сарын 08-ны өдөр Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газар, Улаан Загалмайн хорооны салбар нэгжтэй хамтран “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах”, “Түлэгдэлтийн үед үзүүлэх анхны тусламж” сэдэвт, Өмнөд бүс дэх газар 03 дугаар сарын 07, 09 дүгээр сарын 04-ний өдөр Өмнөговь аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах” сэдэвт, Баян-Өлгий аймаг дахь хэлтэс нь аймгийн Онцгой байдлын газартай хамтран 05 дугаар сарын 07-ны өдөр “Гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл”, “Гамшгаас хамгаалах арга хэмжээ” сэдэвт, 11 дүгээр сарын 04-ний өдөр аймгийн Цагдаагийн газар, “Жолоочийн чадамжийн төв” ТББ-тай хамтран, “Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам”, “Замын хөдөлгөөний дүрмийн шинэчилсэн зохицуулалт, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулжээ.</p> <p>Баруун бүс дэх газар нь 04 дүгээр сарын 30-ны өдөр Ховд аймгийн Онцгой байдлын газарт галын дүгнэлт, эрсдэлийн үнэлгээ хийлгүүлэхээр 14/24 дугаар албан бичгийг хүргүүлж, 05 дугаар сарын 17-ны өдрийн 0011510 дугаар галын дүгнэлтийг гаргуулан авсан.</p> <p>Монгол Улсын шадар сайд Дорноговь аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээний хүрээнд 11 дүгээр сарын 12-ноос 13-ны өдрүүдэд зохион байгуулсан гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгт Дорноговь аймаг дахь газар хамрагдаж, энэхүү чиглэлээр зохион байгуулсан 8 цагийн сургалтад 3 албан хаагч хамрагдсан.</p> <p>Хилийн боомт, орон нутаг дахь нэгжүүд хилийн боомтод ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдаа байгалийн давагдашгүй хүчин зүйл, гэнэтийн аюул ослоос урьдчилан</p>

		сэргийлж аюулгүй ажиллагааны зааварчилга өгч, тухай бүр гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байна.
6	“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) систем хэвийн ажиллагаа алдагдах, мэдээллийн сан устах, гэмтэх үед дахин сэргээгдэхгүй байхаас урьдчилан сэргийлэх	Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд бүртгэлтэй 235 албан хаагч албан хэрэгцээндээ ашиглаж байна. Системд хандаж байгаа төхөөрөмжүүдийг бүртгэлжүүлэх эрхийн тохиргооны программ хангамжийн хөгжүүлэлт хийгдэж байгаа бөгөөд 2024 онд багтаан бүрэн бүртгэлжүүлэхээр ажиллаж байна. Үндсэн болон тестийн гэсэн 2 төрлийн серверийг Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан (ISF) системд ашиглаж байна. Хандалтын лог, үйлдлийн лог, нөөцийн логийг бүртгэлжүүлж, өгөгдлийн сангийн нөөцлөлтийг өдөр бүр бүтэн гарган ажиллаж байна. Системд нэвтрэлтийн аюулгүй байдлын түвшинд давхар шатлалт (two factor authentication) нэвтрэлтийг шийдэж, хөгжүүлэлтийг эхэлж 2024 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс нэвтрүүлэхээр ажиллаж байна.
7	Хадгаламжийн нэгжүүд цаасан баримтад байгаа тохиолдолд эрсдэл бий болсноор нөхөн сэргээгдэх боломжгүй тул цахим хэлбэрт шилжүүлэх, хортон шавж, мэрэгч амьтдаас урьдчилан сэргийлэх	Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/222 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, байгууллагын даргын 2023 оны А/65 дугаар тушаалаар баталсан “Цахим баримт бүрдүүлэх, хөтлөх, архивд шилжүүлэх журам”-ын дагуу байгууллагын төвд 01 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд 2022 оны хөрөнгө оруулагчийн 262 хадгаламжийн нэгжийн 5898 хуудас баримтыг PDF өргөтгөлтэй цахимжуулж, 112 хадгаламжийн нэгжийн 707 хуудас нийт 374 хадгаламжийн нэгжийг цахимжуулж, и-архив программд холбож баримтын эх хувийг ашиглалтаас чөлөөлж эрсдлээс хамгаалах арга хэмжээ авсан. Төвийн байранд байрлах А, Б хадгаламжийн санд “Болор ариусгал” ХХКомпаниар 05 дугаар сарын 28, 11 дүгээр сарын 11-ний өдөр хортон шавж устгалын ажил хийлгэж, архивын баримтыг гадны эрсдэлээс хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.